



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.ХЭРҮҮГА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.24 № 3/559
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. А. А.

Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663.Цахим
хаяг:naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахимхаяг:
Sambuunyamy@ audit.gov.mn

Аудитор: Д.Ганбилэг
Утас: 260512
Цахим хаяг:
Ganbilegd@ audit.gov.mn

YAG-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 03 дугаар сар31

Аудитынтайлан

сралт 1: Агуулга

сралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2, 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/319/СТА-ТШЗ / аудит хийлээ.

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн 2016оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 18-наас 2016 оны 3 дугаар сарын 15–ны хооронд хийхээр төлөвлөн “Баталгаа аудит” ХХК-ийн ахлах болон туслах аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 3 дугаар сарын 7-нд “Баталгаа аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Баталгаа аудит” ХХК аудитыг 2017оны 1 дүгээр сарын 18-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 25-нд Хөдөө аж ахуйн их сургуулийнудирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Хөдөө аж ахуйн их сургуулийн байгууллагын төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”,Нягтлан бодох бүртгэлийн тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Дээд боловсролын тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Нийгмийн даатгалын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Боловсролын тухай зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт орсон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлд... Дээд боловсролын байгууллагын зорилгыг... 2.1-д ... Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино... гэжээ.

Сургуулийн Удирдах зөвлөлийн 2013 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Хөдөө аж ахуйн их сургуулийн дүрэм”-ийг баталсан бөгөөд 1.3-д ...Их сургуулийн үндсэн зорилго нь иргэнд дээд боловсрол эзэмшүүлэх, шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа эрхлэн шинэ мэдлэг бүтээх, хүн амд мэдлэг түгээх, боловсрол, соёлын төвшинг нь дээшлүүлэхэд оршино..., 1.3.1-д ... ХААИС-ийн эрхэм зорилго нь хөдөөгийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, сургалтыг үйлдвэрлэл, бизнестэй хосолсон манлайлах их сургууль болоход оршино... гэжээ. 1.5-д ... Их сургууль нь үндсэн үйл ажиллагаа/сургалт, мэдлэг үйлдвэрлэх/-ны хувьд ашгийн төлөө бус байгууллага бөгөөд зардлаа нөхөх санхүү, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, суралцагч, багш, ажиллагсдын ажиллаж амьдрах орчин, нөхцөл, материаллаг хангамжийг дээшлүүлэх, мэдлэгийг үйлдвэрлэл, бизнес болгох чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулна... гэжээ.

ХААИС-ийн алсын хараа нь “тогтвортой хөгжлийн төлөө”, эрхэм зорилго нь “Азийн шилдэг их сургуулийн эгнээнд багтах”, үнэт зүйлс нь “суралцах таатай орчин, оюунлаг, бүтээлч, хариуцлагатай хамт олон, эрдэм мэдлэг, амьдрах чадвар, ёс зүйтэй оюутнууд, хөгжил дэвшилд манлайлагч байх, эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах” зэрэг болно.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга/захирал, эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хөдөө аж ахуйн их сургуулийн 2016 оны төсвийг Сангийн яамны санхүүжилт болон суралцагсдын сургалтын төлбөр, бусад орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Тус сургууль нь өөрийн харьяа Мал эмнэлэгийн сургууль, Мал аж ахуй,биотехнологын сургууль, Инженер технологийн сургууль, Аэроэкологын сургууль, Эдийн засаг, бизнесийн сургууль, Төв сургуулийн захиргаа аж ахуй гэсэн 6 нэгжийн санхүүгийн тайланг нэгтгэн ХААИС-ийн санхүүгийн нэгдсэн тайланг гаргажээ.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил17-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хөдөө аж ахуйн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан сургуулийн захирлын тушаалаар батлуулан 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөнажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэнбайна.ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэнбайна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд баг буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн заалттай тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хөдөө аж ахуйн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуусанхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал

ХААИС-ийн материаллаг байдлыг тогтоохдоо тус сургуулийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн 17,447,586,272.0 төгрөгийн “нийт зардал” гэсэн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон сонгон авч 1%-иар тооцож 174,475,862.0төгрөгөөр тогтоолоо.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хөдөө аж ахуйн их

сургуулийндотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Сургуулийн дотоод хяналтын албанд 2016 оны 4 дүгээр сараас дотоод аудиторор Б.Номин ажиллаж эхэлсэн байна. Дотоод аудитор нь 2016 оны 11 дүгээр сарын 2-ноос 22-ны өдрүүдэд сургуулийн эхний 10 сарын цалингийн гүйлгээнд аудит хийсэн байна. Энэ хяналтаар нийт 5 төрлийн зөрчил илрүүлэн зохих арга хэмжээ авчээ. Илэрсэн зөрчлүүд нь: 2016 оны 1 дүгээр сард нийт цалинг шинэчлэн тогтоохдоо ажилласан жил, албан тушаалын зэрэглэлийг 205 ажилтан дээр буруу тогтоосон, ажилтнуудын цалинг 10-15%-иар нэмэгдүүлэн тооцохдоо зарим хүний нэмэгдлийн тооцоололтыг буруу хийсэн, цагийн бүртгэлийн системийг бүх ажилтнууд ашиглахгүй, цаг ашиглалтын хяналт муу, илүү цагийн мөнгийг захирлын тушаалгүй олгосон, ажилтнуудын ур чадварын нэмэгдлийг захирлын тушаал шийдвэргүй, ур чадварыг журмын дагуу дүгнээгүй тогтмол олгодог, хоол, унааны мөнгийг цалинтай чөлөөтэй ажилтнуудад олгосон зэрэг олон зөрчил илрүүлж холбогдох арга хэмжээг авчээ.

Мөн 2016 оны 12 дугаар сарын 9-нөөс 26-ны өдрүүдэд 2016 оны 9,10 дугаар саруудын кассын гүйлгээг түүвэрлэн шалгаж нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас айрагны үнэ төлсөн, оюутнуудыг ногоон байгууламжинд ажиллуулж олгох ажлын хөлсний дүнгээр сургалтын төлбөрийн авлагыг бууруулсан, баримт дутуу байх зэрэг зөрчил гарчээ.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 онд улсын төсвөөс олгох тогтмол зардлыг сар, улирлын хуваарийн дагуу БСШУЯ-ны Төрийн сангаас тус сургуулийн ХААНБ дахь харилцах дансанд шилжүүлжээ. Тус сургууль нь ХААН, Төрийн, Голомт зэрэг арилжааны банкуудад харилцах данс нээлгэн гүйлгээ явуулж байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс тогтмол зардалд 735.7 сая төгрөгийн санхүүжилт авч, сургалтын төлбөрөөр 12,479.2 сая, сургалтын төрийн сангаас 419.1 сая, ШУТ сангаас 272.4 сая, үндсэн бус үйл ажиллагаанаас 2,455.3 сая төгрөгийн нийтдээ 14,317.2 сая төгрөгийн орлого оруулжээ. Тус сургууль 2016 онд 16,733.9 сая төгрөгийг зарцуулсан байна. ХААИС 2016 оны эхэнд харилцах данс, кассата 1,725.4 сая төгрөгийн, оны эцэст 2,748.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ХААИС-ийн Удирдах зөвлөл сургуулийн төсвийг хичээлийн жилээр тооцон баталж ирсэн бөгөөд батлагдсан төсөв нь санхүүгийн жилтэй тохирдоггүй байна. Өөрөөр хэлбэл санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31 хүртэл байхад тус сургуулийн төсвийг 2014 оны 8 дугаар сарын 1-нээс 2015 оны 8 дугаар сарын 1-ний өдөр, 2015 оны 8 дугаар сарын 1-нээс 2016 оны 8 дугаар сарын 1-ний өдөр, 2016 оны 8 дугаар сарын 1-нээс 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл тооцож баталдаг байна. Жишээ нь: ХААИС-ийн Удирдах зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 8-ны 12 тоот тогтоолоор 2015/2016 оны хичээлийн жилийн төсвийн орлогыг 14,791.8 сая төгрөгөөр, зарлагыг 14,742.7 сая төгрөгөөр баталсан байна. Харин 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс сургуулийн удирдах зөвлөл ХААИС-ийн төсвийг санхүүгийн жилээр батлан мөрдүүлж эхэлжээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу ХААИС нь 2015 оны турш "shilendans.gov.mn/org/5719" гэсэн линкээр/хаягаар/ шилэн дансанд мэдээлэлээ оруулж иржээ. Харин 2016 оноос дээрх хаягийг Сангийн яамнаас "infoshilendans.gov.mn/login" болгон өөрчилсөн байна. Тус сургууль нь төсвийн болон төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлбол: Багш, ажилчдад олгодог унаа, хоолны хөнгөлөлтийн мөнгийг амралтын дундаж цалинд оруулан тооцож 2015 онд 675 хүнд 45.7 сая төгрөгийг илүү олгосон боловч 2016 онд хувь хүмүүсээс суутган төлүүлээгүй, шүүхийн шийдвэртэй, данс бүртгэлд тусгагдсан 462.0 сая төгрөгийн авлагыг графикайн дагуу төлүүлээгүй, 2013 оны 3 сард 3.0 сая төгрөгөөр худалдан борлуулалдсан 2004 оны 9 дүгээр сарын 1-нд ашиглалтанд орсон 28-28УБД улсын дугаартай "Тоёото Ланд круйзер" маркийн суудлын автомашиныг бэлэн байгаагаар/үлдэгдэл өртөг байхгүй/ бүртгэж ирсэн, сургуулийн авто тээврийн хэрэгсэлийн данс бүртгэлд 49 нэрийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 22 нэрийн 261.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл үлдэгдэл өртөгтэй, үлдэх 27 тээврийн хэрэгсэл нь үлдэгдэл өртөггүй болсон, төв болон харьяа 5 сургуульд элэгдлээрээ үнэ нөхөж үлдэгдэл өртөггүй болсон 2443 нэрийн 1,593.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байгаа зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 45 хувь, мөнгөн хөрөнгийн 96 хувь, нийт зардлын 89 хувь, нийт хөрөнгийн 85 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрлээ. Үүнд:

1. ХААИС нь Хөдөлмөрийн тухай хуулийн 48.2 зүйл, НХХ сайдын 2005 оны 55 тоот тушаалаар батлагдсан зааврын 4 дүгээр зүйлийг зөрчин 2015 онд байгууллагаас олгодог унаа, хоолны хөнгөлөлтийн мөнгийг ажиллагсдын амралтын дундаж цалинд оруулан тооцож 675 хүнд 45.7 сая төгрөгийг илүү олгосон зөрчил 2015 онд гарсан бөгөөд 2016 онд суутган тооцож төлүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 48.2 дугаар заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Дундаж хөлс тодорхойлох журам”-ын 4-д...Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсэний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй..., Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10-д ... аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх... гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

2. ХААИС-ийн Инноваци, технологи дамжуулах төвд ашиглагдаж байсан УБД 28-28 улсын дугаартай, 1994 онд үйлдвэрлэгдсэн “Тоёота Ландкрузер” автомашиныг “Хөдөөг хөгжүүлэх сургалт” төсөлд зориулан 2004 онд худалдан авч 2004 оны 9 дүгээр сарын 1-нд 16.2сая төгрөгөөр данс бүртгэлд тусгажээ. 2013 оны 3 дугаар сарын 1-нд болсонтөвийн хамт олны хурлын шийдвэрээр уг автомашиныг 3.0 сая төгрөгөөр худалдан борлуулсан байна.Гэтэл уг автомашиныг 3 жил гаруй хугацаанд бэлэн байгаагаар/үлдэгдэл өртөг байхгүй/ бүртгэж ирсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д...Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна..., Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1-д ... Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.31.3. 2-д... илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох..., 71-1-1-д...үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд

бүрдүүлсэн байх, 73-2-д... Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана...гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Дүүргийн эрүүгийн хэргийн 2 дугаар шатны шүүхийн 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 180 тоот шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2015 оны 3 дугаар сарын 26-ний өдрийн 236 тоот магадлалыг үндэслэн гаргасан 2015 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн 956 тоот гүйцэтгэх хуудсанд заасан 468.0 сая төгрөгийг тус сургуулийн захирал байсан Бадарчийн Бямбаагаар төлүүлж тус сургуулийн дансанд оруулахаар ХААИС-ийн Эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан дэд захирал Ж.Батчулуун 2015 оны 6 дугаар сарын 30-ны 1 тоот “Төлбөр тооцооны гэрээ”-г байгуулж Б.Бямбаа, Ж.Батчулуун нар гарын үсэг зуржээ. Энэ гэрээний 1.2-д зааснаар дээрхи төлбөрийг 2015 оны 10 дугаар сараас 2016 оны 4 дүгээр сарыг дуустал төлж барагдуулахаар график гаргажээ. Гэвч хариуцагч Б.Бямбаа нь төлбөрийг төлөөгүй, сургуулийн зүгээсудаа дараа шаардлага тавьж байсан боловч хэрэгжүүлээгүй явж ирсэн байна. Үүний улмаас 468.0 сая төгрөгийн төлбөр төлөгдөхгүй шүүхийн шийдвэр биелэгдэхгүйд хүрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д ...эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах..., Төсвийн тухай хуулийн 6.4.8-д.. төсвийг зохистой удирдаж авлага, өр, төлбөр үүсгэхгүй байх... гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

2.Төв болон харьяа 5 сургуульд элэгдлээрээ анхны үнээ нөхөж үлдэгдэл өртөггүй болсон 2443 нэрийн 1,593.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байгаа бөгөөд цаашид эдгээрийг дахин үнэлж элэгдэл тооцох, актлаж устгах, худалдах, шилжүүлэх арга хэмжээг тухай бүр аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1-д ... Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно. 31.3. 2-д... илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох...заалтуудыг мөрдөж ажиллах

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад дараа тайлангийн тооцоогоор олгосон зарим мөнгөний зарцуулалтын тайланг гаргахдаа анхан шатны баримт дутуу, бүрдэлгүй байсан 15.3 сая төгрөгийн алдааг залруулсан болно. Залруулагдаагүй алдааг менежментийн захидалд оруулсан болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл 3 сая төгрөгөөр борлуулсан боловч дансны үлдэгдлээр бүртгэгдэж байгаа автомашин /Менежментийн захидалын тэргүүлэх ач холбогдол №2-ын асуудал-1/, байгууллагаас олгодог унаа хоолны 45.7 сая төгрөг амралтын дундажид оруулж илүү тооцсон /Менежментийн захидалын тэргүүлэх ач холбогдол №1-ийн Асуудал-1-д байгаа/, 25.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнийг аудитын явцад арилгуулсан бөгөөд нийт 74.3 сая төгрөгийг засч залруулах үүрэг өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 7 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 6-г хэрэгжүүлж, 1-ийг бүрэн хэрэгжүүлээгүй, 85.7%-тай байна.

Зөрчилгүй санал дүгнэлт өгөх үндэслэл

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг болон материаллаг бус зөрчлүүд илэрлээ. Үүнд: хоол, унааны хөнгөлөлтийг дундаж цалинд оруулан тооцож илүү олгосон 45.7 сая төгрөгийг хувь хүнээр төлүүлээгүй, захирал байсан Б.Бямбаагаар төлүүлэх, авлагын дансанд бүртгэлтэй, шүүхийн шийдвэртэй 468.0 сая төгрөгийг төлүүлээгүй, 2013 онд худалдагдсан автомашиныг бэлэн байгаагаар бүртгэж ирсэн, Төв болон харьяа 5 сургуульд элэгдлээрээ анхны үнээ нөхөж үлдэгдэл өртөггүй болсон 2443 нэрийн 1,593.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байгаа бөгөөд цаашид эдгээрийг дахин үнэлж элэгдэл тооцох, актлаж устгах, худалдах, шилжүүлэх арга хэмжээг тухай бүр аваагүй зэргээр нийтдээ 2,107.5 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрлээ. Мөн шалгалтын явцад 15.3 сая төгрөгийн зарцуулалтын баримтыг нь аудитын хугацаанд бүрдүүлсэн болно.

Цаашид Хөдөлмөрийн тухай хуулийн 48.2 дугаар зүйл, үүнийг үндэслэн гаргасан Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 4 дүгээр зүйлд “...хөнгөлөлтийн орлого /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй...” гэсэн заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн “Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого” гэсэн 32 дугаар зүйлийн 32.1.4-д “...аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн

хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого...” гэсэн заалтууд хоорондоо зөрчилдөж байна гэж ойлгож байна. Өөрөөр хэлбэл хоол, унааны хөнгөлөлтийг дундаж цалинд оруулахгүй атлаа нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах орлогод оруулан тооцож байна. Энэ зөрчил нь ихэнх их, дээд сургуулиудад адил байгаа тул ҮАГ-аас холбогдох дээд шатны байгууллагад асуудал тавих нь зүйтэй гэж төлбөрийн акт тогтоогоогүй бөгөөд үүнийг материаллаг бус зөрчилд оруулан тооцлоо.

Тус сургуулийн захирал байсан Б.Бямбаагаар шүүхийн шийдвэрээр тус сургуульд төлүүлэх нийт 468.0 сая төгрөгийг 2015, 2016 онуудад төлүүлэхээр төлбөр тооцооны гэрээ хийсэн боловч гэрээний үүрэг биелэгдээгүй тул аудитын зүгээс зөвлөмж өгсөн бөгөөд сургууль нь 2015 оноос эхлэн 468.0 сая төгрөгийг авлагын дансанд бүртгэсэн тул материаллаг зөрчилд оруулаагүй болно.

Мөн тус сургуулийн Төсвийн гүйцэтгэлийн тайлан урсгал болоод хөрөнгө оруулалтын нийт зарлага цэвэр зээлийг санхүүжүүлэх төлөвлөгөөнөөс 48 нэр төрлийн зардал 494.1 сая төгрөгөөр хэмнэгдэж 21 нэр төрлийн зардал 375.5 сая төгрөгөөр хэтэрч нийт дүнгээрээ 118.6 сая төгрөг буюу 0.7 хувиар хэмнэлттэй ажиллаж нийт зардлын нэр төрлийн 70 орчим хувьд боломжтой үнэлгээ өгөхүйц дүнтэй байгааг тэмдэглэж байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөө аж ахуйн их сургуулийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 18 хуудас, хавсралтууд 12 хуудсыг тус тус хавсаргав.



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Илүү олгосон 45.7 сая төгрөгийг хувь
хүмүүсээр төлүүлээгүй.....

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Худалдан борлуулагдсан
автомашиньг 3 жил гаруй хугацаанд
данс бүртгэлээс хасалгүйгээр бэлнээр
бүртгэж ирсэн.....

Асуудал 2

Б.Бямбаагаар шүүхийн
шийдвэртэй, данс бүртгэлд тусгасан
468.0 сая төгрөгийг гэрээний дагуу
толүүлээгүй.....

Асуудал 3

Элэгдлээрээ анхны өртгөө
нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлыг
шийдвэрлээгүй.....

2017оны 03 дугаар сар 31

Менежментийн захидал

Үндэсний аудитын газартай хийсэн гэрээний дагуу “Баталгаа аудит”ХХК-ийн хийсэн аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийгөглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн завсарын аудитын санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс завсарын аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллагатай хийсэн гэрээний дагуу энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хөдөө аж ахуйн их сургуулийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Илүү олгосон 45.7 сая төгрөгийг хувь хүмүүсээр төлүүлээгүй

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:ХААИС нь Хөдөлмөрийн тухай хуулийн 48.2 зүйл, НХХ сайдын 2005 оны 55 тоот тушаалаар батлагдсан зааврын 4 дүгээр зүйлийг зөрчин 2015 онд байгууллагаас олгодог унаа, хоолны хөнгөлөлтийн мөнгийг ажиллагсдын амралтын дундаж цалинд оруулан тооцож 675 хүнд 45.7 сая төгрөгийг илүү олгосон зөрчил 2015 онд гарсан бөгөөд 2016 онд суутган тооцож төлүүллээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10-д ... аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх...,Аудитын тухай хуулийн 14.2.5-д ...шалгалтын явцад илэрсэн бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлантай холбоотой хүлээн зөвшөөрсөн алдаа, зөрчлийг шуурхай залруулах...гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах. зөвлөмж өгөв.

Эрсдэлүүд: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10, Аудитын тухай хуулийн 14.2.5 тоот заалтууд зөрчигдөхөд хүрнэ.

Төсвийн захирагчийн хариу:Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 1: Худалдан
борлуулагдсан автомашины
3 жил гаруй хугацаанд данс
бүртгэлээс хасалгүйгээр
бэлнээр бүртгэж ирсэн**

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт: . ХААИС-ийн Инноваци, технологи дамжуулах төвд ашиглагдаж байсан УБД 28-28 улсын дугаартай, 1994 онд үйлдвэрлэгдсэн "Тоёота Ландкрузер" автомашиныг "Хөдөөг хөгжүүлэх сургалт" төсөлд зориулан 2004 онд худалдан авч 2004-9-1-нд 16.2сая төгрөгөөр данс бүртгэлд тусгажээ. 2013 оны 3 сарын 1-нд болсон төвийн хамт олны хурлын шийдвэрээр уг автомашиныг 3.0 сая төгрөгөөр худалдан борлуулсан байна. Гэтэл уг автомашиныг 3 жил гаруй хугацаанд бэлэн байгаагаар/үлдэгдэл өртөг байхгүй/ бүртгэж ирсэн байна.

